

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБА

Хяналтад байгаа тогтоол, шийдвэрийн 2015 оны гүйцэтгэлийн мэдээ
(Захирамжлалын баримт бичгийн хэрэгжилт)

2015.12.18

№	Эрх зүйн акт огноо, дугаар:	Заалт	Хэрэгжилт Гүйцэтгэлийн хувь (%)	Хяналтанд байгаа заалтыг хэрэгжүүлэх талаар төлөвлөсөн арга хэмжээ	Үр нөлөө
1	Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн 2014 оны жилийн эцсийн дүнг. 2015-03-30 Дугаар 18 Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	<p>3.1. Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр Засгийн газар, сайд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосон заалт бүрийг хяналтад авч, хэрэгжүүлэх ажлыг төлөвлөгөөтэй, шуурхай зохион байгуулах;</p> <p>3.2. Биелэлтийг тогтоосон хугацаанд нь Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн систем (www.unelgee.gov.mn)-д байршуулах, хэрэгжилтийг бодитой тайлагнах, үнэлэх;</p> <p>3.3. 2014 оны жилийн эцсийн байдлаар тасарсан болон хэрэгжилт нь удааширч байгаа заалтуудыг хэрэгжүүлэх, хэрэгжсэн заалтуудыг хяналтаас хасуулах;</p> <p>3.4. Хуульд заасан дүрэм, журмуудыг батлан мөрдүүлэх.</p>	<p>3.1. Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр Засгийн газар, сайд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосон заалт бүрийг хяналтанд авч байгууллагын жилийн төлөвлөгөөнд уялдуулан нийт 29 тогтоол, шийдвэрийн 83 заалтын хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлсэн.</p> <p>3.2. unelgee.gov.mn системд манай байгууллага бүртгэлгүй тул тус заалтыг цаашид хяналтаас хасуулах саналтай байна.</p> <p>3.3. 2014 оны жилийн эцсийн байдлаар тасарсан болон хэрэгжилт нь удааширч байгаа заалт байхгүй болно.</p> <p>3.4. Байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх 8 журам батлан, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. 100%</p>	Байгууллагын 2015 оны үйл, ажиллагааны жилийн төлөвлөгөөнд: 2.4 Дээд газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахад хэлтсүүдийн үйл ажиллагааг чиглүүлэх	Дээд газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангасан.

2	Шилэн даансны тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2015-02-26 Дугаар 13 Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	<p>2.1.1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан тайланг улирал тутам гаргаж Сангийн яаманд хүргүүлж, холбогдох мэдээллийг цахим хуудсандаа тогтоосон хугацаанд байршуулж байх;</p> <p>2.1.2. Шилэн дансны тухай хуулийн 8.2-т заасны дагуу харьяа байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах.</p>	<p>2.1.1 Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан тайланг 2015 оны 5 дугаар сарын 18-нд Сангийн яаманд хүргүүлсэн. Холбогдох мэдээллийг ulaanbaatar.mn болон internalaudit.ub.gov.mn цахим хуудсанд мэдээлсэн.</p> <p>Сангийн сайдын 2015 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 13—1/5581 дугаар албан бичгийн дагуу тус алба нь Нийслэл болон 9 дүүргүүдийн харьяа 719 байгууллагын шилэн дансны мэдээллийг 5 хавсралт бүхий маягтын дагуу 2015 оны I, II, III улирлаар нэгтгэн цахимаар болон албан бичгээр хүргүүлсэн болно.</p> <p>2.1.2 Нийслэлийн нутгийн захиргааны 90 байгууллага /төсөвт-70, ОНӨААТҮГ-20/, дүүргүүдийн 630, нийт 720 байгууллагын “Шилэн дансны тухай хууль, журам”-ын хэрэгжилтийн 2015 оны 1, 2, 3 дугаар саруудын мэдээг авч нэгтгэсэн бөгөөд 2015 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр Нийслэлийн Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсан. Мөн 2015 оны 1-5 дугаар сарын мэдээг нэгтгэн Нийслэлийн Дотоод аудитын хорооны хуралд 2015 оны 06 дугаар сарын 11-ний өдөр танилцуулсан.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2015 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/01 дүгээр захирамжийн дагуу 1-6 дугаар сарын байдлаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд үзлэг тооллого явуулж, Нийслэл, 9 дүүргээр нэгтгэн нийт 719 байгууллагын мэдээлэл, үзлэгийн нэгдсэн тайланг Нийслэлийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн 8 дугаар сарын 27-ний өдрийн хуралд танилцуулсан.</p> <p>100%</p>	<p>Байгууллагын 2015 оны үйл, ажиллагааны жилийн төлөвлөгөөнд: 1.2.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үйл явц, үр дүн.</p>	<p>Дээд газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангасан.</p> <p>Нийслэлийн байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, нийслэлийн удирдлагыг энэ талаарх мэдээллээр хангасан.</p>
3	Үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг	3.1.Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан "Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам"-	3.1. Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1146 захирамжаар баталсан хяналт,	Байгууллагын 2015 оны үйл, ажиллагааны	Төрөөс явуулж буй бодлогыг хэрэгжүүлж,

	<p>хэрэгжүүлж ажиллах тухай 2014-06-21 Дугаар 32 Засгийн газрын хуралдааны тэмдэглэл</p>	<p>ын дагуу хийсэн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах</p> <p>3.2. Нийслэлийн батлагдсан засаглалын болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлтийг хангах, төлөвлөлтийн үйл ажиллагааг үнэлгээтэй уялдуулан ажиллах</p> <p>3.3. Бодлогын баримт бичгүүдийн тайлан, мэдээг байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлаар оруулан хэлэлцүүлж санал, дүгнэлтийн хамт ирүүлж байхыг, мөн тодорхой асуудлаар холбогдох байгууллага, албан тушаалтнаас өгсөн зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж, гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө гарган тайлагнаж байхыг үүрэг болгов.</p>	<p>шинжилгээ, үнэлгээний журмын дагуу хийсэн үнэлгээний дүгнэлт зөвлөмжийг байгууллагын 2015 оны үйл, ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлэн ажилласан.</p> <p>3.2 Нийслэлийн батлагдсан засаглалын болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлтийг хангах, төлөвлөлтийн үйл ажиллагааг үнэлгээтэй уялдуулан 2015 оны үйл, ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгасан.</p> <p>3.3. Бодлогын баримт бичгүүд, тогтоол шийдвэрийн биелэлтийн тайлан мэдээг байгууллагын удирдлагаар хянуулж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. 100%</p>	<p>жилийн төлөвлөгөөнд: 2.4 Дээд газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахад хэлтсүүдийн үйл ажиллагааг чиглүүлэх</p>	<p>тайланг хугацаанд нь хүргүүлж байна.</p>
4	<p>Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай 2014-05-10 Дугаар 147 Засгийн газрын тогтоол</p>	<p>1.1) Чиг үүргийн давхардалтай эсхүл нэг төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн харьяанд байгаа чиг үүрэг ойролцоо, харилцан уялдаа бүхий үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа төсөвт байгууллагуудыг нэгтгэн зохион байгуулах замаар удирдлагын зардлыг бууруулах;</p> <p>1.3) Бүх шатны Засаг даргын орлогч, төсөвт байгууллагын дэд дарга, яам, агентлагын газрын орлогч дарга, даргын туслах, төсвөөс цалинждаг зөвлөх зэрэг орон тоог цөөлөх, цомхотгох;</p> <p>1.4) Төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах үүрэгтэй харуул хамгаалалт, халаалт дулаан, цэвэрлэгээ зэрэг үйлчилгээг гэрээний үндсэн дээр хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх, төрийн албаны гэрээт ажилтны орон тоог 50 хувиар бууруулах санал боловсруулж шийдвэрлүүлэх;</p> <p>3.3) Шинээр орон тоо нэмэгдүүлэхгүй байх, ажлын байрны ачааллыг нягтруулж орон тоог бууруулах, сул чөлөөтэй орон тоонд томилгоо хийхгүй байх замаар цалингийн зардлыг хэмнэх;</p>	<p>1.1 Тус байгууллагад чиг үүргийн давхардалтай эсхүл нэг төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн харьяанд байгаа чиг үүрэг ойролцоо, харилцан уялдаа бүхий үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа төсөвт байгууллага байхгүй болно.</p> <p>1.3 Тус байгууллагад орлогч дарга, даргын туслах, төсвөөс цалинждаг зөвлөх зэрэг орон тоо байхгүй болно.</p> <p>1.4 Байгууллагын хэмжээнд 2015 онд хувийн хэвшлээр гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ байхгүй. Төрийн албаны гэрээт ажилтан байхгүй.</p> <p>3.3 Шинээр орон тоо нэмээгүй болно.</p>	<p>Байгууллагын 2015 оны үйл, ажиллагааны жилийн төлөвлөгөөнд: 2.6 Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг хууль журамд нийцүүлэн олон улсын стандартын дагуу хөтлөн явуулах</p>	<p>Төсвийн гүйцэтгэлийн 47 хувийн хэмнэлттэй ажилласан.</p>

		<p>3.4) “Суудлын автомашины талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2007 оны 349 дүгээр тогтоолоор тогтоосон албан тушаалын болон албан ажлын автомашины хэрэглээний зардлыг 20 хүртэл хувиар хэмнэх;</p> <p>3.5) Гадаад албан томилолтын зардлыг бууруулах, зайлшгүй тохиолдолд зорчих төлөөлөгчийн тоог цөөлөх, төсвийн хөрөнгөөр бизнес ангиллын нислэгээр зорчихгүй байх;</p> <p>3.6) Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр, ялангуяа төсвийн нэмэлт орлого, хандив болон тусламжийн орлогоор гадаад, дотоодын тойрон аялал, зугаалга, ой тэмдэглэх арга хэмжээ, урлагийн наадам, уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх;</p> <p>3.7) Хурал, сургалт, зөвлөгөөний давтамжийг багасгах, зайлшгүй хийх тохиолдолд төлөөлөгчдийн тоог цөөн, оновчтой, богино хугацаанд хийхээр эсхүл цахим хэлбэрээр зохион байгуулах;</p> <p>3.8) Төрөөс иргэд, аж ахуйн нэгж, хувийн хэвшилд үзүүлж буй үйлчилгээг цахим технологи, сүлжээ ашиглан чирэгдэлгүй хурдан, шуурхай хүргэх замаар төсвийн урсгал зардлыг бууруулах, энэ чиглэлээр шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;</p> <p>3.9) Орон нутгийн байгаль, цаг уурын нөхцөлд нийцүүлж спорт заал, соёлын төв зэрэг төсөвт байгууллагын барилга байгууламжийг төвлөрсөн дулааны системд холбох, сэргээгдэх эрчим хүч, цахилгаан халаалт зэрэг бусад үр ашигтай арга, технологи нэвтрүүлэх замаар түлш, халаалтын зардал хэмнэх, цаашид ийм төрлийн зардлыг тогтмол түвшингээр төсөвлөх, улмаар үе шаттай бууруулах;</p> <p>3.1.төсвийн санхүүжилтийг бууруулснаар өр, авлага үүсгэхгүйгээр зардал хэмнэх боломжийг дайчлах</p> <p>3.2.улсын төсвийн татаас, орон нутгийн төсвийн урсгал зардлыг 20-иос доошгүй хувиар</p>	<p>3.4 2015 оны үйл ажиллагаанд автомашины зардлыг 57,6% буюу 3046,0 мянган төгрөгөөр хэмнэсэн.</p> <p>3.5 Гадаад сургалт, албан томилолтын зардал гараагүй.</p> <p>3.6 Гадаад, дотоодын тойрон аялал, зугаалга, ой тэмдэглэх арга хэмжээ, урлагийн наадам, уралдаан тэмцээн зохион байгуулаагүй.</p> <p>3.7 Хурал, сургалт, зөвлөгөөний зардал гараагүй болно.</p> <p>3.8 Тус байгууллага нь иргэд, аж ахуйн нэгж, хувийн хэвшилд шууд үзүүлж буй үйлчилгээ байхгүй болно.</p> <p>3.9 Тус байгууллага нь спорт заал, соёлын төв зэрэг үйлчилгээ үзүүлдэггүй болно.</p> <p>3.1 Тайлант хугацаанд өр, авлага үүсгээгүй болно.</p> <p>3.2 Засгийн газрын 2014 оны 147-р тогтоолын дагуу төсвийн гүйцэтгэлийн 59,6 хувийн</p>		
--	--	--	--	--	--

		<p>бууруулах</p> <p>4. Яам, агентлаг, төсөвт байгууллагууд төв, орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан төсвийн хөрөнгөөр олон нийтэд зайлшгүй мэдээлэх хууль тогтоомж, албан ёсны шийдвэр болон тэдгээрийн хэрэгжилтийг сурталчлан таниулахаас бусад зорилгоор өөрийн байгууллага, хамт олныг рекламдах, телевизийн шоу уралдаан, тэмцээн зохион байгуулах, цуврал олон ангит кино хийхгүй бөгөөд баяр ёслол, байгууллага, салбарын ой, тэмдэглэлт өдөр зохион байгуулахтай холбогдуулан төсвийн хөрөнгөөр цаасан мэндчилгээ илгээх, бэлэг дурсгалын зүйлс, цүнх, календарь зэрэг зүйлс бэлтгэх, ивээн тэтгэхийг хориглосугай.</p>	<p>хэмнэлттэй ажиллаж байна.</p> <p>4. Ийм төрлийн зардал гараагүй болно.</p> <p>100%</p>		
5	<p>ӨРГӨДӨЛ ГОМДЛЫГ ШУУРХАЙ ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ 2014-03-07 Дугаар 09 Засгийн газрын хуралдааны тэмдэглэл</p>	<p>2.1 Иргэдээс төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлыг хууль тогтоомжийн хүрээнд судлан бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх, иргэдийг чирэгдүүлэхгүй байх, хуулийн хугацаанд иргэдэд хариу өгч хэвших</p> <p>2.2.Тайлан мэдээг хуулийн хугацаанд үнэн зөв, бодитой, тодорхой гаргаж байх</p> <p>2.3.Өргөдөл гомдлын асуудлаар албан хаагчдад сургалт зохион байгуулах, асуудал хариуцсан албан хаагчдын ур чадварыг сайжруулах.</p>	<p>2.1 Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг smartcity.mn програмд бүртгэн, хариуг өгч байна. 2015 онд нийт 32 өргөдөл, гомдол ирсэн бөгөөд үүнээс хуулийн хугацаанд нь 81,25 %-ийг шийдвэрлэсэн.</p> <p>2.2 Тайлан мэдээг smartcity.mn програмаар хуулийн хугацаанд үнэн зөв, бодитой, тодорхой гаргасан.</p> <p>2.3 Өргөдөл гомдлын асуудал хариуцсан албан хаагч Нийслэлийн Засаг Даргын тамгын газрын Иргэд хүлээн авах төвөөс зохион байгуулсан “Өргөдөл, гомдлын, шийдвэрлэлтийг цахимжуулан, индексжүүлж үр дүнг тооцох нь” сэдэвт сургалтанд 2015 оны 03 дугаар сарын 05-ны өдөр хамрагдсан. 100%</p>	<p>Байгууллагын 2015 оны үйл, ажиллагааны төлөвлөгөөнд:</p> <p>2.3.2. Байгууллага, иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг бүртгэн авч, хугацаанд нь шийдвэрлэх</p>	<p>Иргэдээс ирсэн 20 өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн.</p>
6	<p>Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам батлах тухай 2013-12-14 Дугаар 411 Засгийн газрын</p>	<p>2. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, бүх шатны төсөвт байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн удирдлагуудад үүрэг</p>	<p>2. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт дараах мэдээллүүдийг нийтлэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Шилэн дансны мэдээлэл: <p>Холбогдох хууль, журмын дагуу байгууллагын цахим хуудсанд шилэн дансны мэдээллийн</p>	<p>Байгууллагын 2015 оны үйл, ажиллагааны төлөвлөгөөнд:</p> <p>2.7 Байгууллагын ил тод нээлттэй байдлыг хангах</p>	<p>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг</p>

	ТОГТООЛ	болгосугай.	<p>цэс үүсгэж, шилэн дансны нэгдсэн системд 2015 оны төсөв, 2015 оны 1-11 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, 1, 2, 3 дугаар улирлын санхүүгийн тайлан;</p> <ul style="list-style-type: none"> • Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор: <p>Байгууллагын нэр, лого, эрхэм зорилго, стратегийн зорилт, бүтэц зохион байгуулалт, дагаж мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, холбоо барих хаяг, хүний нөөцийн бодлогын ил тод байдлын 14 мэдээлэл, Нийслэлийн Дотоод аудитын албаны 2014 оны үйл ажиллагааны тайлан, тогтоол, шийдвэрийн 2014 оны гүйцэтгэлийн мэдээ, 2014 оны авилгын эсрэг хэрэгжүүлсэн ажлын тайлан, мэдээллийн ил, тод байдал, иргэдийн мэдээлэл хүлээн авах эрхийг хангаж ажиллах 2014 оны төлөвлөгөөний тайлан, 2014 оны өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дэлгэрэнгүй тайлан, 2015 оны эхний хагас жилийн KPI, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2015 оны ажлын төлөвлөгөө, 2015 оны сургалтын төлөвлөгөө, 2015 оны сургалтын төлөвлөгөөний эхний хагас жилийн тайлан, Авилгын эсрэг хэрэгжүүлэх ажлын 2015 оны төлөвлөгөө, Авилгын эсрэг хэрэгжүүлэх 2015 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн тайлан, Архивын хадгаламжийн нэгжийг гамшгийн эрсдэлээс хамгаалах төлөвлөгөө, Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэхэд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, 2015 оны эхний хагас жилийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дэлгэрэнгүй тайлан;</p> <ul style="list-style-type: none"> • Хүний нөөцийн бодлогын ил тод байдлыг хангах зорилгоор: 	журмын хэрэгжилт хангагдсан.
--	---------	-------------	---	------------------------------

			<p>Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтны ёс зүйн дүрэм, ажлын байрны тодорхойлолт, мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм, төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тооны зар;</p> <ul style="list-style-type: none"> Төсөв, санхүүгийн ил тод байдал, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор: Байгууллагын 2015 оны төсөв, 1-11 -р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, 1-3 -р улирлын санхүүгийн тайлан, 2014 оны санхүүгийн тайлан, 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, 2016 оны төсвийн төсөл, 2017-2018 оны төсвийн төсөөлөл; <p>бусад хууль тогтоомжид заасан мэдээллийг нийтлэв. 100%</p>		
7	<p>“Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж байх тухай 2007-05-24 Дугаар 97 Ерөнхийлөгчийн Зарлиг</p>	<p>1. “БНМАУ-ын тусгаар тогтнолын талаархи асуудлын талаар бүх ард түмний саналыг гаргуулах тухай” БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1945 оны түүхэн шийдвэрийн дагуу Монгол Улсын тусгаар тогтнолыг баталгаажуулсан ард түмний санал асуулгыг явуулсан өдрийг тохиолдуулан Засгийн газар, орон нутгийн удирдлага, тэдгээрийн харъяаны бүх шатны байгууллага, албан тушаалтнууд бодлого боловсруулах, шийдвэр гаргахдаа иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын санал, зөвлөгөөг сонсч тусгах зорилгоор жил бүрийн 10 дугаар сарын 20-нд орон даяар “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж ажиллахыг Засгийн газарт чиглэл болгосугай.</p> <p>2. Бүтэн жилийн турш иргэдээс ирүүлсэн бүтээлч, ажил хэрэгч саналыг гүйцэтгэх удирдлагын байгууллагууд, холбогдох албан тушаалтан хүлээн авах, шийдвэрлэх, хэрэгжүүлэх, тэдгээрийн нийгэм, эдийн засаг,</p>	<p>Нийслэлийн Дотоод аудитын алба нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 129 дүгээр тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийг баримтлан ажилладаг. Энэ дүрмийн 4.2. “Дотоод аудитын нэгж нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяанд ажиллана. Дотоод аудитын нэгжийн дарга болон аудитор нь зөвхөн төсвийн ерөнхийлөн захирагчид ажлаа тайлагнана.” гэж заасан байдаг. Иймээс манай байгууллагын хувьд “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулах боломжгүй тул цаашид энэ эрх зүйн актыг хяналтаас хасуулах саналтай байна.</p>	-	-

		улс төрийн амьдралд үзүүлж байгаа эерэг үр дүн, үр нөлөөг нэгтгэн дүгнэж, ард түмэндээ мэдээлж байдаг эргэх холбооны тогтолцоог Засгийн газрын хэмжээнд бүрэлдүүлэн ажиллах нь зүйтэй гэж үзсүгэй. 4. Иргэдээс гарах санал, санаачилгыг ажил хэрэг болгох талаар гүйцэтгэх удирдлагын зүгээс авч буй арга хэмжээнүүдийг байнга сурталчлах, түгээх явдалд идэвх санаачилгатай оролцохыг нийт хэвлэл, мэдээллийн байгууллага, ажилтнуудад уриалсугай.			
8	Журам батлах тухай 2014-05-23 Дугаар А/409 Нийслэлийн Засаг даргын Захирамж	1. “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын Удирдах албан тушаалтнуудын ээлжийн амралт эдлэх, чөлөө авах журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, Нийслэлийн Удирдах зөвлөлийн гишүүн, Нийслэлийн Засаг даргын зөвлөхөд өгөх чөлөөний хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар, Нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагад өгөх чөлөөний хуудасны загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.	1 Нийслэлийн Дотоод аудитын албаны дарга /удирдах албан тушаалтан/-ын хувьд ээлжийн амралт эдлэх, чөлөө авахдаа тус журмыг мөрдөн ажиллсан байгаа бөгөөд 2015 онд чөлөө аваагүй болно. 100%	Байгууллагын 2015 оны үйл, ажиллагааны жилийн төлөвлөгөөнд: 2.4 Дээд газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахад хэлтсүүдийн үйл ажиллагааг чиглүүлэх	Байгууллагын тасралтгүй үйл ажиллагаа хангагдаж, дүрмээр хүлээсэн үүрэг биелэсэн.
9	Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 2015-05-11 Дугаар 184 Засгийн газрын тогтоол	7. Албан ажлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан өөрөө хүсэлт гаргасан тохиолдолд ажлын хоногт 50 км-ээс хэтрүүлэхгүйгээр 1 км-ийг 450 төгрөгөөр тооцож, зардлыг сар тутамд олгож байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга болон холбогдох бусад албан тушаалтанд зөвшөөрсүгэй. 8. Төсвөөс санхүүждэг байгууллага хот дотор ажил, үйлчилгээнд хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж нь 2500 см ³ -ээс дээш, туулах чадвар өндөртэй, шатахуун их зарцуулдаг автомашин хэрэглэх, бүх шатны байгууллага, албан тушаалтан эрхлэх асуудлын хүрээний болон харьяа байгууллагаас автомашин гаргуулан	7. Ийм төрлийн үйл ажиллагаа гараагүй болно. 8. Нийслэлийн автобаазаас албан хэрэгцээний автомашин хэрэглэдэг ба хөдөлгүүрийн багтаамж нь 1300 см ³ болно. 100%	Байгууллагын 2015 оны үйл, ажиллагааны жилийн төлөвлөгөөнд: 2.6 Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг хууль журамд нийцүүлэн олон улсын стандартын дагуу хөтлөн явуулах	2015 оны эхний хагас жилийн байдлаар үйл ажиллагаанд автомашины зардлыг 55,4% буюу 2228,0 мянган төгрөгөөр хэмнэлттэй ажилласан.

		хэрэглэх, шатахууны зардлыг төлүүлэхийг тус тус хориглосугай.			
10	“Улаанбаатар хотын Эдийн засгийн хөгжлийн стратеги баримт бичиг”-ийг батлах тухай 2015-04-30 Дугаар 26/08 Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол	2.1 Стратеги баримт бичигт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулах; 2.2 Стратеги баримт бичгийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улс, нийслэлийн төсөвт тусгах, хандивлагч орнуудын зээл, тусламжид хамруулах, төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах замаар санхүүжүүлэх ажлыг зохион байгуулах; 2.3 Стратеги баримт бичгийн биелэлтийг жил бүр гаргаж Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулах;	2.1. Тус баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхтэй холбоотой манай байгууллагад өгсөн үүрэг даалгавар байхгүй болно. 2.2. Тус заалтад манай байгууллагад өгөгдсөн үүрэг даалгавар байхгүй тул цаашид хяналтаас хасуулах саналтай байна. 2.3. Тус заалтад манай байгууллагад өгөгдсөн үүрэг даалгавар байхгүй тул цаашид хяналтаас хасуулах саналтай байна.	Байгууллагын 2015 оны үйл, ажиллагааны жилийн төлөвлөгөөнд: 2.4 Дээд газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахад хэлтсүүдийн үйл ажиллагааг чиглүүлэх	Одоогоор манай байгууллагад гарсан үр нөлөө тодорхойгүй байна.

11	Ажил эрчимжүүлэх тухай 2015-04-21 Дугаар А/328 Нийслэлийн Засаг даргын Захирамж	<p>1. Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай. 2. Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох ажлыг удирдамжийн дагуу дүүргийн нутаг дэвсгэрт яаралтай зохион байгуулж ажиллахыг дүүргүүдийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p> <p>3. Өөрийн байгууллагаас гарч байгаа хог хаягдлыг зориулалтын хогны уутанд хийж, хуваарийн дагуу хог тээврийн машинд ачуулж хэвшүүлэх ажлыг зохион байгуулахыг дүүрэг, хорооны Засаг дарга, нийслэлийн, дүүргийн харьяа газар, агентлагуудын дарга нарт тус тус үүрэг болгосугай.</p> <p>4. Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох үйл ажиллагаатай холбоотойгоор Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/-т даалгасугай.</p> <p>5. Улаанбаатар хотын иргэд, оршин суугчид, байгууллага аж ахуйн нэгжүүдэд хог хаягдлын чиглэлээр хийгдэж байгаа ажлыг шуурхай сурталчилж ажиллахыг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс /Б.Түвшинтөгс/-т даалгасугай.</p>	<p>1. Тус заалтад манай байгууллагад өгөгдсөн үүрэг даалгавар байхгүй тул цаашид хяналтаас хасуулах саналтай байна.</p> <p>3. Тус байгууллага хаягдал цаасаа автомат цаас жижиглэгч машинаар жижиглэн зориулалтын уутанд хийж, хаягдал цаас боловсруулах үйлдвэрт хүргүүлж хэвшсэн.</p> <p>4. Тус заалтад манай байгууллагад өгөгдсөн үүрэг даалгавар байхгүй тул цаашид хяналтаас хасуулах саналтай байна.</p> <p>5. Тус заалтад манай байгууллагад өгөгдсөн үүрэг даалгавар байхгүй тул цаашид хяналтаас хасуулах саналтай байна.</p>	Байгууллагын 2015 оны үйл, ажиллагааны жилийн төлөвлөгөөнд: 2.4 Дээд газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахад хэлтсүүдийн үйл ажиллагааг чиглүүлэх	Дээд газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангасан.
12	Нийслэлийн 2015 оны төсвийн орлого бүрдүүлэх, зардал хэмнэх зарим арга хэмжээний тухай 2015-04-20 Дугаар А/312 Нийслэлийн	1. Төсвийн орлогын ноогдлыг бүрэн хийх, ноогдуулсан татварыг хураан барагдуулах, орлогын бааз суурийг өргөжүүлэх чиглэлээр эрчимжүүлсэн ажил зохион байгуулан, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хамтарсан үзлэг, шалгалт зохион байгуулж, дүүргийн татварын хэлтэс, өмч газрын асуудал эрхэлсэн албад, холбогдох орлого бүрдүүлэгч байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/,	1. Тус заалтад манай байгууллагад өгөгдсөн үүрэг даалгавар байхгүй тул цаашид хяналтаас хасуулах саналтай байна.	Байгууллагын 2015 оны үйл, ажиллагааны жилийн төлөвлөгөөнд: 2.4 Дээд газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахад хэлтсүүдийн үйл	Засаг даргын захирамж хэрэгжиж, хотын тогтвортой хөгжлийг хангахуйц эдийн засагтай хот болох зорилт биелэх нөхцөл бүрдэж

	<p>Засаг даргын Захирамж</p>	<p>нийслэлийн Татварын газар /Б.Ганболд/, Өмчийн харилцааны газар /Ш.Төмөрбаатар/ болон бусад орлого бүрдүүлэгч байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосугай.</p> <p>2.Татвар төлөгчийн бааз суурийг өргөтгөх, далд эдийн засгийг ил болгох, төсвийн орлогын тогтвортой эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд шаардлагатай мэдээ, мэдээллээр татвар болон өмчийн газрыг ханган ажиллахыг бүх дүүрэг, нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагууд, харьяа газрын удирдлагуудад, өгөгдсөн мэдээллийг боловсруулан үйл ажиллагаандаа үр дүнтэй ашиглахыг нийслэлийн Татварын газар /Б.Ганболд/, Өмчийн харилцааны газар /Ш.Төмөрбаатар/-т тус тус даалгасугай.</p> <p>3.Хаяг байршилдаа байхгүй татвар төлөгчийг эрэн сурвалжлах, татварын болон газрын төлбөрийн дутуу төлөлтийг барагдуулах ажлыг эрчимжүүлж, шүүхийн шийдвэртэй өрийг барагдуулах чиглэлээр ажил үүргээ уялдуулан хамтарч ажиллахыг нийслэлийн Татварын газар /Б.Ганболд/, Өмчийн харилцааны газар /Ш.Төмөрбаатар/, Улаанбаатар хотын Цагдаагийн газрын дарга /Ч.Болдбаатар/, нийслэлийн Прокурорын газар /Б.Амгаланбаатар/, нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба /Т.Энхбат/-нд тус тус үүрэг болгосугай.</p> <p>4.Улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар ажил гүйцэтгэн санхүүжилт авсан, ажил гүйцэтгэсэн боловч санхүүжилт нь олгогдоогүй хүлээгдэж \D:\2015 захирамж\захи.docx 2 байгаа аж ахуйн нэгж байгууллагуудын судалгааг харилцан солилцож өр барагдуулах чиглэлээр хамтран ажиллахыг Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар /Л.Нарантуяа/, Авто замын газар /Д.Нанзаддорж/, Татварын газар /Б.Ганболд/, Өмчийн харилцааны газар /Ш.Төмөрбаатар/-т</p>	<p>2. Нийслэлийн Дотоод аудитын хорооны даргын баталсан “2015 оны аудитын жилийн төлөвлөгөө”-ний дагуу нийслэлийн засаг даргын хамрах хүрээний 42 байгууллагад санхүүгийн болон гүйцэтгэлийн аудит хийхээс эхний хагас жилд 42 байгууллагад аудит хийхдээ Засаг даргын уг захирамжийг нэг шалгуур үзүүлэлт болгон авч үзэж байна.</p> <p>3. Тус заалтад манай байгууллагад өгөгдсөн үүрэг даалгавар байхгүй тул цаашид хяналтаас хасуулах саналтай байна.</p> <p>4. Тус заалтад манай байгууллагад өгөгдсөн үүрэг даалгавар байхгүй тул цаашид хяналтаас хасуулах саналтай байна.</p>	<p>ажиллагааг чиглүүлэх</p>	<p>эхэлнэ.</p>
--	------------------------------	---	---	-----------------------------	----------------

	<p>тус тус үүрэг болгосугай.</p> <p>5.Нийслэлийн Засаг даргын 2003 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш гаргасан захирамжийн дагуу нийслэлийн нутаг дэвсгэрт дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаас бусад хэлбэрээр газар эзэмшиж, ашиглаж буй иргэн хуулийн этгээд нь өөрийн газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний хугацааг сунгах, нэр шилжүүлэх, зориулалт өөрчлөх хүсэлт гаргасан тохиолдолд газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг нөхөн авч төсөвт төвлөрүүлэх, анхны үнийг нөхөн төлүүлж байж холбогдох эрхийг баталгаажуулан ажиллахыг Өмчийн харилцааны газар /Ш.Төмөрбаатар/, Ерөнхий төлөвлөгөөний газар /Н.Нацагдорж/- т тус тус үүрэг болгосугай.</p> <p>6.2015 оны өмч хувьчлал, газрын дуудлага худалдааг зохион байгуулах бэлтгэл ажлыг шуурхай ханган, батлагдсан жагсаалт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу өмч хувьчлал, газрын дуудлага худалдааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, төсвийн орлогын бүрдүүлэлтийг ханган ажиллахыг нийслэлийн Өмчийн харилцааны газар /Ш.Төмөрбаатар/-т үүрэг болгосугай.</p> <p>7.Нийслэлийн шалган бүртгэх товчоодоос төсөвт төвлөрүүлж буй авто зам ашигласны төлбөр болон нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа төлбөртэй зогсоолын үйл ажиллагаа, түүнээс төсөвт төвлөрч буй орлогын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах замаар орлогын гүйцэтгэлийг хангах, шаардлагатай тохиолдолд гэрээний үүргээ биелүүлээгүй, төлбөрийн орлогыг тухай бүрт төсөвт төвлөрүүлээгүй хуулийн этгээдтэй байгуулсан гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авч ажиллахыг нийслэлийн Авто замын газар /Д.Нанзаддорж/-т даалгасугай.</p> <p>8.Дүүргүүдийн төсвийн орлогын төлөвлөгөөг ханган биелүүлэхийн зэрэгцээ хотын төсөвт</p>	<p>5. Тус заалтад манай байгууллагад өгөгдсөн үүрэг даалгавар байхгүй тул цаашид хяналтаас хасуулах саналтай байна.</p> <p>6. Тус заалтад манай байгууллагад өгөгдсөн үүрэг даалгавар байхгүй тул цаашид хяналтаас хасуулах саналтай байна.</p> <p>7. Тус заалтад манай байгууллагад өгөгдсөн үүрэг даалгавар байхгүй тул цаашид хяналтаас хасуулах саналтай байна.</p> <p>8. Тус заалтад манай байгууллагад өгөгдсөн үүрэг даалгавар байхгүй тул цаашид</p>		
--	--	--	--	--

		<p>төвлөрч буй татварын болон татварын бус орлогын бүрдүүлэлтийг хангах, дутуу төлөлтийг барагдуулах чиглэлээр холбогдох орлого бүрдүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллахыг дүүргүүдийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p> <p>9.Улс болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудын татвар, газрын төлбөрийн өр барагдуулах ажлыг орлого бүрдүүлэгч байгууллагуудтай хамтран зохион байгуулахыг Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/-т даалгасугай.</p> <p>10.Засгийн газрын 2014 оны “Төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” 147 дугаар тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангаж, 2015 оны урсгал зардлыг хэмнэж 2014 оны түвшинд тооцох, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх талаар бодитой ажил зохион байгуулж, ажлын төлөвлөгөө гаргаж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт үүрэг болгосугай.</p> <p>11.Нийслэл, дүүргийн харьяа газар, байгууллага, хэлтсүүдийн төсвийн зардлын зарцуулалтанд хяналт тавьж, дүгнэлт гаргах ажлын хэсгүүдийг байгуулж, гүйцэтгэл үр, дүнг тайлагнаж, ажиллахыг Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/-т үүрэг болгосугай.</p> <p>12.Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын 2015 оны үйл ажиллагааны зардлыг тухайн үйлдвэрийн газрын 2014 оны батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэлээс хэтрүүлэхгүй баталж, зардлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Өмчийн харилцааны газар /Ш.Төмөрбаатар/-т үүрэг болгосугай.</p>	<p>хяналтаас хасуулах саналтай байна.</p> <p>9. Тус заалтад манай байгууллагад өгөгдсөн үүрэг даалгавар байхгүй тул цаашид хяналтаас хасуулах саналтай байна.</p> <p>10.Засгийн газрын 147-р тогтоолын дагуу шинэ орон тоо нэмээгүй ба, төсвийн гүйцэтгэлийн 59,6 хувийн хэмнэлттэй ажиллаж байна.</p> <p>11. Тус заалтад манай байгууллагад өгөгдсөн үүрэг даалгавар байхгүй тул цаашид хяналтаас хасуулах саналтай байна.</p> <p>12. Тус заалтад манай байгууллагад өгөгдсөн үүрэг даалгавар байхгүй тул цаашид хяналтаас хасуулах саналтай байна.</p> <p>100%</p>		
--	--	---	--	--	--

